



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

УЛСЫН ТӨСВИЙН 2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ



УЛААНБААТАР ХОТ
2019 ОН

	Агуулга	Хуудасны дугаар
Аудитыг гүйцэтгэсэн: Гүйцэтгэлийн аудитын хэлтсийн дарга бөгөөд менежер:	Товчилсон үгийн тайлбар	1
	Ерөнхий зүйл	2-3
Ахлах аудитор:	Бүлэг 1. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт үндэслэлтэй хийгдсэн байна уу?	4-5
	Төсвийн тухай хуульд төлөвлөлтийн алдаатай, хуулийн шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгажээ.	4-5
Аудитор:	Бүлэг 2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна уу?	6-14
	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй байна.	6
Гэрээт ажилтан:	Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль, журмын холбогдох заалтыг мөрдөөгүй байна.	6
	Гүйцэтгэгч гэрээний үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлэн ажиллаагүй байна.	10
3.Түвшинжаргал	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт 68.9 хувийн гүйцэтгэлтэй байна.	10
	Барилгын ажил гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийн ажлын хариуцлага сул байгаагаас зураг, төсөвт заасан ажлын тоо хэмжээг дутуу, чанаргүй гүйцэтгэжээ.	11
	Захиалагч гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.	12
	Ажлын гүйцэтгэлийг бодитой хянаагүйгээс хийгээгүй ажлын гүйцэтгэлд санхүүжилт олгосон байна.	13
		14
	Бүлэг 3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг тооцож байна уу?	14
	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг, үр нөлөөг төлөвлөх, тооцох эрх зүйн орчин бүрдээгүй байна.	14
	Дүгнэлт	11
	Зөвлөмж	16
	Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар 327787 дугаарын утсаар харилцана уу.	Холбогдох байгууллагын санал
	Нийслэл дэх Төрийн аудитын газрын тайлбар	17
	Хавсралтууд	18-21
Хаяг: 14200, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Бага тойруу-1, Г.Амарын гудамж-2, Нийслэлийн Соёлын төв өргөө, Г корпус, НТАГ		

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БСШУСС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, соёлын сайд
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, соёлын яам
БХБС	Барилга хот байгуулалтын сайд
БХД	Багахангай дүүрэг
ДХААА	Дүүргийн худалдан авах ажиллагааны алба
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
НАЗХГ	Нийслэлийн Автозамын хөгжлийн газар
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НӨХГ	Нийслэлийн Өмчийн харилцааны газар
НД	Налайх дүүрэг
ННЗБ	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НСТСХ	Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс
НХААГ	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар
НХОГ	Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар
СХД	Сонгинохайрхан дүүрэг
СБД	Сүхбаатар дүүрэг
СС	Сангийн сайд
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТББ	Тендерийн баримт бичиг
ТБОНӨБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХУД	Хан-Уул дүүрэг
ЧД	Чингэлтэй дүүрэг
УБЗАА	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ҮАГ	Үндэсний Аудитын газар
УИХ	Улсын Их хурал
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХААА	Худалдан авах ажиллагааны алба
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ХО	Хөрөнгө оруулалт
ХНХС	Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМС	Эрүүл мэндийн сайд

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 06 дугаар тогтоол, МУ-ын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2018 онд нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон НТАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт:

“Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө”-нд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийнэ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төлөвлөлт үндэслэлтэй хийгдсэн байна уу?
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна уу?
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг тооцсон уу?

Хамарсан хүрээ:

Аудитад нийслэлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд санхүүжүүлсэн 92 төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд болон төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч байгууллагуудын үйл ажиллагааг хамрууллаа.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглах бөгөөд шалгагдагч байгууллагуудын холбогдох албан тушаалтнууд, судлаачид, шинжээчидтэй ярилцлага хийх, асуулга, лавлагаа болон судалгаа авах, байгууллагын худалдан авалт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд дүн шинжилгээ хийж аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана. Үүнд:

- Авто замын тухай хууль;
- Барилгын тухай хууль;
- Батлагдсан зураг, төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт
- ЗГ-ын 2017 оны 69, 2017 оны 172, 2018 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан “Барилын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм”;

- ЗГ-ын 2018 оны 140 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”;
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Сангийн сайдын 2017 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;
- Сангийн сайдын 2016 оны “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”;
- Төсвийн тухай хууль;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль.

Стандартын талаарх мэдэгдэл:

- Төрийн аудитын тухай хууль, Гүйцэтгэлийн аудитын АДБОУС 300, АДБОУС 3000, АДБОУС 3100, “Төрийн хяналт шалгалтын стандарт”, “Гүйцэтгэлийн аудитын журам”-ыг тус тус мөрдөж ажиллаа.

10. Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн, хугацаа, баталгаажуулалт:

Аудитыг НТАГ-ын Гүйцэтгэлийн аудитын хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер Н.Энхбат хянан удирдаж, ахлах аудитор С.Зоригт, аудитор Д.Дариймаа, гэрээт ажилтан З.Түвшинжаргал нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Тайланг НТАГ-ын Удирдлагын зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж А/08 тоот тушаалаар баталгаажуулав.

БҮЛЭГ А. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ ҮНДЭСЛЭЛТЭЙ ХИЙГДСЭН БАЙНА УУ?

Ерөнхий мэдээлэл:

Нийслэлд Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-аар “Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга”-ын багцад 1 080.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1, “Хууль зүй, дотоод хэргийн сайд”-ын багцад 500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1, “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд”-ын багцад 800.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1, “Барилга, хот байгуулалтын сайд”-ын багцад 55 546.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15, “Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд”-ын багцад 92 184.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 58, “Зам, тээврийн хөгжлийн сайд”-ын багцад 11 029.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10, “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд”-ын багцад 2,230.0 сая төгрөгийн төсөв өртөгтэй 6 ТАХ, нийт 163 369.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 92 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталжээ.

Хүснэгт 1: Нийслэлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээний судалгаа

№	Төсвийн ерөнхийлөн захирагчийн жагсаалт	Өмнөх оноос шилжиж ирсэн		Шинээр хэрэгжих		2018 оноос дамжих		Нийт	
		Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг
1	ЗГХЭГ-ын дарга	0	-	0	-	1	1,080.0	1	1,080.0
2	ХЗДХ-ийн сайд	0	-	1	500.0	0	-	1	500.0
3	ХНХ-ын сайд	0	-	0	-	1	800.0	1	800.0
4	БХБ-ын сайд	5	48,942.1	8	1,504.0	2	5,100.0	15	55,546.1
5	БСШУС-ын сайд	2	704.60	15	3,918.9	41	86,491.9	58	92,184.4
6	ЗТХ-ийн сайд	0	-	7	2,185.4	3	8,844.0	10	11,029.4
7	ХХААХҮ-ийн сайд	0	-	4	530.0	2	1,700.0	6	2,230.0
8	ЭМ-ийн сайдын	0	-	1	2,800.0	0	-	1	2,800.0
	Нийт	7	49,646.7	35	11,438.3	50	104,015.9	93	166,169.90

Нийслэлд 2018 онд 2014-2018 онд шилжиж ирсэн БХБС-ын 48 942.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5, 2018 онд шинээр эхэлж хэрэгжиж дуусах ХЗДХС-ын 500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1, БХБС-ын 1 504.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8, БСШУСС-ын 3 918.9 сая төгрөгийн 15, ЗТХС-ын 2 185.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7, ХХААХҮС-ын 530.0 сая төгрөгийн 4, 2018-2020 онд дамжин хэрэгжих ЗГХЭГ-ын даргын 1 080.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1, ХНХС-ын 800.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1, БХБС-ын 5,100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2, БСШУСС-ын 86 491.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 41, ЗТХС-ын 8 844.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3, ХХААХҮС-ын 1 700.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ-нүүд тус тус шилжин ирж, шинээр болон дамжин хэрэгжиж байна.

Төсвийн тухай хуульд төлөвлөлтийн алдаатай, хуулийн шаардлага хангахгүй ТАХ-г хэрэгжүүлэхээр тусгажээ.

1.1 Байршил, хүчин чадал зөрүүтэй, зураг төсөв нь баталгаажаагүй, газрын асуудал шийдэгдээгүй ТАХ батлагдсанаас хэрэгжүүлэх явцад хүндрэл үүсчээ. Тухайлбал:

Байршил, хүчин чадал зөрүүтэй:

- ЧД-ийн 5 дугаар сургуулийн өргөтгөлийг 320 хүүхдийн хүчин чадалтай барихаар баталсан. Нийслэлээс тус сургуулийн өргөтгөлийн зураг, төслийг 640 хүүхдийн хүчин чадалтайгаар боловсруулсан байдаг бөгөөд хүчин чадал зөрүүтэй байгаагаас шалтгаалан өнөөг хүртэл ХАА-г зохион байгуулж чадаагүй;
- СХД-ийн 10 дугаар хороонд цэцэрлэгийн барилга буулгаж, 280 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилга барихаар хөрөнгө батлагдсан боловч СХД-ийн 10 дугаар хороонд 2004 онд баригдаж, 2011 онд өргөтгөл хийгдсэн 170 хүүхдийн хүчин чадалтай төрийн өмчийн 38 дугаар цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд өөр буулгах цэцэрлэгийн барилга байхгүйгээс хэрэгжээгүй;
- БНД, ХУД-т баригдах Инженерийн хийцтэй гүний худгууд нь хэрэгцээ, шаардлагагүй газар байршлаа олоогүй төлөвлөснөөс хэрэгжээгүй.

Баталгаажсан зураг төсөвгүйгээр:

2018 онд шинээр эхэлсэн буюу зураг төсөвт өөрчлөлт орсон эрх шилжсэн төсөл, арга хэмжээний судалгаагаар нийслэл, дүүргүүд, нийслэлийн агентлаг, байгууллагуудад хэрэгжих 62 ТАХ-г зураг төсөвгүйгээр 2018 онд шинээр батлуулсан байна. Тухайлбал:

- ЗГХЭГ-ын даргын 1;
- ХЗДХС-ын 1;
- ХНХС-ын 1;
- БХБС-ын 3;
- БСШУСС-ын 15;
- ЗТХС-ын 6 ажлыг тус тус баталгаажсан зураг төсөвгүйгээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Газрын асуудал шийдэгдээгүй:

Нийслэлд баригдахаар төлөвлөсөн сургууль цэцэрлэгийн 31 барилгын газрыг чөлөөлөхөд нийслэлийн төсвөөс 2018 онд 9.0 тэрбум төгрөгийг зарцуулсан ч газар чөлөөлөх зардал жишиг газрын үнээс харьцангуй их байгаагаас шалтгаалан газрын асуудлыг шийдвэрлэх боломжгүй болжээ.

1.2 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар шинээр 63 ТАХ-ний зураг төсөв хийгдэхээр төлөвлөсний 43-д зурагт магадлал хийлгэсэн, 19-д зурагт магадлал хийгээгүй, 19-г зураг төсөв боловсруулж байжээ. Үүний 26-д түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр гэрээ байгуулжээ. Дэлгэрэнгүйг “Хавсралт 1”-ээр үзүүлэв.

БҮЛЭГ 2. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮНТЭЙ БАЙНА УУ?

ХО-ын ТАХ-ний хэрэгжилт төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй байна.

Ерөнхий мэдээлэл:

УТХО-аар нийслэлд 2018 онд шинээр хэрэгжүүлэхээр 121 745.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 93 ТАХ-ний ХАА-г явуулсан байна. Үүнээс НХААГ-т 68 057.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 53, НАЗХГ-т 6 185.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9, НӨХГ-т 1,285.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1, УБЗАА-нд 1 500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1, БГД-т 1 750.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5, БНД-т 68.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3, СХД-т 16 960.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12, ХУД-т 9 754.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ТАХ-нд ХАА-г зохион байгуулжээ.

ХАА-г зохион байгуулахдаа хууль, журмын холбогдох заалтыг мөрдөөгүй байна.

2.1.1 2018 онд 93 ТАХ-ний ХАА-г зохион байгуулснаас нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 80 буюу 86.0 хувийг, харьцуулалтын аргаар 13 буюу 14.0 хувийг тус тус зохион байгуулжээ.

2.1.2 Нийслэлд явагдсан ХАА-ны тендерийн хэмнэлтийг болон үнэлгээний хорооны тушаал байгуулснаас хойш гэрээ байгуулах эрх олгох хүртэлх хугацааг ТЕЗ-аар ангилж үзүүлбэл:

Хүснэгт 2: Нийслэлд явагдсан ХАА-ны тендерийн хэмнэлт болон тендер шалгаруулалтад зарцуулсан хугацааны хүснэгт

№	Төсвийн ерөнхийлөн захирагчид	Тендерийн хэмнэлт, сая төгрөгөөр	Тендерт зарцуулсан хоног, хуанлийн хоногоор	
			Бодит	Дунджаар
1	ЗГХЭГ	151.1	193	193.0
2	БОАЖС	83.6	71	71.0
3	ХЗДХС	12.7	123-129	126.0
4	ХНХС	164.8	47-149	85.7
5	БХБС	247.8	31-227	136.3
6	БСШУСС	6,992.0	14-309	135.4
7	ЗТХС	1,048.5	56-131	81.2
8	ХХААХҮС	228.0	59-242	143.2
9	ЭМС	8.3	91.5	91.5
	ДҮН	8,929.0		

2.1.3 НХААГ, ДХААА, агентлагуудад явагдсан ТАХ-ний тендерийн хэмнэлт 8 929.0 сая төгрөг болжээ.

2.1.4 Дээрх хүснэгтээс үзэхэд НХААГ, ДХААА, агентлагуудад үнэлгээний хороо байгуулагдсанаас хойш дунджаар 71-193 хоног зарцуулж гүйцэтгэгчийн сонгон шалгаруулжээ. Дэлгэрэнгүйг “Хавсралт 2”-оор үзүүлэв.

2.1.5 Зарим ажлын үнэлгээний хороо байгуулагдсанаас хойш гэрээ байгуулах эрх олгох хүртэл ихээхэн хугацаа зарцуулж, барилгын ажил гүйцэтгэх дулааны улирал өнгөрсөн үед зөвлөмж гарч байгаа нь хөрөнгө оруулалтын ажил он дамжин хийгдэх, нэмэгдэл санхүүжилтийн эх үүсвэр шаардагдах зэрэг эрсдэлийг бий болгож байна. Үүнд үнэлгээний хорооны гишүүдийг хэд, хэдэн удаа сольдог, ТББ-ийг шаардлагын түвшинд боловсруулагдаагүй зэрэг үнэлгээний хорооны үйл ажиллагаатай холбоотой зөрчлүүд мөн нөлөөлж байна.

2.1.6 Нийт 11 840.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ТАХ-ний газрын асуудал шийдэгдээгүй шалтгаанаар тендер шалгаруулалт явуулаагүй байна. Үүнд:

- Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /СБД, 11 дүгээр хороо/, төсөвт өртөг 2840.0 сая төгрөг;
- Цэцэрлэгийн барилга, 200 ор /БГД, 16 дугаар хороо, Гандангийн дэнж/, төсөвт өртөг 2000.0 сая төгрөг;
- Цэцэрлэгийн барилга, 150 ор /БЗД, 4, 5, 14 дүгээр хороо/, төсөвт өртөг 1500.0 сая төгрөг;
- Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих 280 ор /СХД, 10 дугаар хороо/, төсөвт өртөг 1500.0 сая төгрөг;
- Оюуны спортын ордны барилга /ХУД/, өртөг 4000.0 сая төгрөг;

2.1.7 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар УТХО-аар нийслэлд ХАА зохион байгуулагдсан 110,301.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 88 ТАХ-нээс 91 160.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 74 ТАХ-нд гүйцэтгэгчийг шалгаруулж гэрээ хийгджээ. Харин 1 305.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ-нд ТББ-ийг боловсруулж байгаа, 5 457.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ-нд гэрээ байгуулах зөвлөмжийг хүргүүлсэн, 12 098.5 сая төсөвт өртөгтэй 6 ТАХ-нд тендерийн үнэлгээ хийгдэж байгаа, 280.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ-нд гомдол гарсантай холбоотойгоор эрх бүхий байгууллагаас шийдвэр хүлээгдэж байгаа зэрэг шалтгааны улмаас нийт 14 ТАХ-нд гүйцэтгэгчийг шалгаруулаагүй байна.

Хүснэгт 3: Худалдан авах ажиллагааны явц

Тендер зохион байгуулсан этгээд	Төсөвт өртөг, сая төгрөг	Тендерийн ТББ боловсруулж байгаа	Гэрээ хийх зөвлөмж хүргүүлсэн	Тендерийн үнэлгээ хийгдэж байгаа	Шийдвэр хүлээгдэж байгаа ажил	Гэрээ хийгдсэн	Дүн
НХААГ	7,717.8	1	2	1	1	44	49
НАЗХГ	6,185.8					9	9
НӨХГ	1,285.0	1					1
УБЗАА	1,500.0					1	1
БНД	68.0					3	3
БГД	1,750.0					5	5
СХД	28,068.5		2	4		7	13

2.1.18 Мөн 2018 онд хэрэгжүүлсэн ТАХ-ний ХАА-ны төлөвлөгөө болон хэрэгжилтийн мэдээллийг СС-ын 2012 оны дээрх журмын 2.5¹¹, 3.5¹² дахь заалтуудын дагуу нэгтгэж тайлагнажээ.

2.1.19 “ТЕЗ-ийн 2018 онд зохион байгуулагдах ХАА-ны төлөвлөгөө”-г батлуулан Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлж, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/ болон “Монголын үнэн” сонинд хуулийн хугацаанд нийтэлсэн байна.

2.2. Гүйцэтгэгч гэрээний үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлэн ажиллаагүй байна.

ХО-ын ТАХ-ний хэрэгжилт 68.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.2.1. УТХО-аар 2018 онд нийт 92 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 30 ТАХ буюу 32.6 хувь нь хэрэгжээгүй, хэрэгжилт дутуу байгаа нь нийт санхүүжилтэд батлагдсан хөрөнгийн 31.5 хувийг эзэлж байна. Үүнийг ТЕЗ-аар үзүүлбэл,

Хүснэгт 4: Хэрэгжээгүй төсөл, арга хэмжээний судалгаа, сая төгрөг

№	ТЕЗ	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	БСШУС	17	27,587.0	14,333.0
2	БХБС	8	34,832.1	3,379.6
3	ХХААХҮС	5	1,530.0	1,130.0
	ДҮН	30	63,949.1	18,842.6

2.2.2. Хэрэгжээгүй шалтгааныг дурдвал:

- Газрын асуудал шийдэгдээгүйгээс 7 966.1 сая;
- Тендер оройтож эхэлсэн 1 272.0.0 сая;
- Тендерийн үнэлгээ хийгдэж байгаа 3 845.0 сая;
- Гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлсэн 1 500.0 сая;
- Гомдол гарсан 1 080.0 сая;
- Гэрээ сунгасан 3 109.5 сая;
- эрээ хүчингүй болсон 50.0 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус ашиглах боломжгүй байсан байна.

Дэлгэрэнгүйг “Хавсралт 3”-аар үзүүлэв.

¹¹ “Захиалагч тухайн жилийн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг Маягт 1-ийн дагуу боловсруулж, түүнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал, төсөв, худалдан авах ажиллагаанд мөрдөх журам, хэрэгжүүлэх хугацаа болон холбогдох тайлбар тодруулгыг тодорхой тусгасан байна”,

¹² “Төсвийн ерөнхийлөн захирагч хуулийн 45.1 дэх, 45.2.1 дэх заалтыг үндэслэн батлагдсан багцын хүрээнд өөрийн хэрэгцээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан хэрэгжилтийн, мөн хуулийн 45.4 дэх заалтын дагуу Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага нь тухайн оны худалдан авах ажиллагааны тайланг Маягт 2, 3-ын дагуу нэгтгэн хуулийн 49.5-д заасны дагуу дараа оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ”,

2.2.3 Харин 2018 онд УТХО-аар НСТСХ-ээр дамжин санхүүжилт олгохоор батлагдсан 38 ТАХ-д 28 627.1 сая төгрөгийг төлөвлөснөөс 25,840.6 сая төгрөг олгож, санхүүжилтийн гүйцэтгэл 90.3 хувьтай байна.

Хүснэгт 5: Нийслэлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээний НСТСХ-ээр дамжих санхүүжилтийн судалгаа

№	Төсвийн ерөнхийлөн захирагчид	Төсөл, арга хэмжээний тоо	Төсвийн тухай хуулиар		2018 оны санхүүжилт		
			Төсөвт өртөг	Санхүүжих дүн	2018.12.31-ний байдлаар	2018 онд олгосон санхүүжилт	Төсвийн ерөнхий лөн захирагч, СЯ-аар дамжих
1	ЗГХЭГ-ын дарга	1	1,080.0	580.0	580.0	580.0	
2	ХНХС	1	800.0	600.0	600.0	598.2	ХНХЯ
3	БСШУСС	36	52,583.8	27,447.1	26,034.8	24,662.4	
	Нийт	38	54,463.8	28,627.1	27,214.8	25,840.6	

2.2.4 ТАХ-ний хэрэгжилтэд тавих захиалагч байгууллагын хяналт сул, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар цаг хугацаанд нь арга хэмжээ авдаггүй, ТАХ хэрэгжих хугацаанд тохирсон санхүүжилт хуваарилан төлөвлөж, санхүүжүүлээгүй, зөрчил гаргасан гүйцэтгэгч байгууллагатай хариуцлага бүрэн тооцохгүй байгаагаас хэрэгжилт удаашралтай, улмаар орхигдох нэг шалтгаан болж байна. Тухайлбал,

- “Орон сууцны 14 дүгээр хорооллын цахилгааны 110/35/10 кВт-ын дэд станцын гаргалгаа 4 иж бүрдэл, 10 кВт-ын хаалттай хуваарилах байгууламж 3 иж бүрдэл, 10 кВт-ын хаалттай дэд өртөө 12 иж бүрдэл, 10 кВт-ын 18.4 км кабель шугамын зураг төсөв, барилга угсралтын ажил, “УБ, БЗД”, хэрэгжиж буй хугацаа 2014-2018 он, төсөвт өртөг 7 167.0 сая төгрөг;
- “Улаанбаатар хотын дулаан хангамжийн Ø 800-ийн гол шугамыг Ø 1000 мм голчтой болгон өргөтгөх зураг төсөв, барилга угсралтын ажил /1 дүгээр хорооллын урд талаас баруун 4 замын уулзвар хүртэл, павильон 19-өөс 3/11 холбоос хүртэл 3.4 км, УБ, СХД”, хэрэгжиж буй хугацаа 2014-2018 он, 24 949.0 сая төгрөг;

2.2.5 Харин НХОГ нь зарим гүйцэтгэгчтэй “гэрээний тусгай нөхцөл”-ийн 26.2 дахь хэсэгт зааснаар гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар тооцож нийт 70,500.0 төгрөгийн алданги ногдуулан хариуцлага тооцжээ. Тухайлбал:

- “Цэцэрлэгийн барилгын дээврийн засварын ажил, БГД, 133 дугаар цэцэрлэг”, гүйцэтгэгч Сумангүн констракшн ХХК, алданги 52 500.0 төгрөг;
- “Хүүхдийн тоглоомын талбай байгуулах, УБ, БНД, 4 дүгээр хороо, Тогос уул хэсэг”, гүйцэтгэгч Мөрөөдлийн гүн ухаан ХХК, алданги 18 000.0 төгрөг;

Барилгын ажил гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийн ажлын хариуцлага сул байгаагаас зураг, төсөвт заасан ажлын тоо хэмжээг дутуу, чанаргүй гүйцэтгэжээ.

2.2.5 Гүйцэтгэгч байгууллагын үйл ажиллагаанаас шалтгаалж ТАХ-ний хэрэгжилт удаашрах, барилга байгууламжийн ажлын явцад барилгын норм, дүрэм, стандарт

зөрчигдсөн, хяналтын зураг, төсвийн үзүүлэлт, шаардлагыг хангахгүйгээс барилга байгууламжийн ажлууд чанаргүй хийгдэж байна. Тухайлбал:

БСШУСС-ын багцад:

- “Цэцэрлэгийн барилгын засвар, БНД, 131 дүгээр цэцэрлэг”-ийн засварын ажлыг Хасу консалтинг ХХК гүйцэтгэхдээ гал тогооны өрөөний агааржуулалтын хоолойг стандартын дагуу хийгээгүйгээс агаарын солилцоо хийгдэхгүй болсон, гал тогооны өрөөний шаланд ус урсах налууг зурагт зааснаар хийгээгүй, цонхны тавцан, хана, таазны будаг, шохой хуурсан, ханын плита салж унасан;
- “Хүүхдийн тоглоомын талбай, БНД, 4 дүгээр хороо, Тогос уул хэсэг”-ийн ажлыг Мөрөөдлийн гүн ухаан ХХК гүйцэтгэхдээ “явган хүний замын хашлага тавих” ажилд “явган хүний замын хашлагыг 160 урт/метр хийхээс 120 урт/метр-ийн дутуу хийсэн;
- “125 дугаар сургуулийн барилгын гадна шугам сүлжээний засварын ажил, БНД”-ыг Хүслэн дэлгэрэх ХХК нь гүйцэтгэхдээ “сургуулийн үзель доторх насос дээр даралт хэмжих датчик суурилуулж сургуульд хүлээлгэн өгөөгүй”, “явган хүний замыг нөхөн сэргээх ажлыг хийгээгүй;
- “Туул зөрлөгийн үерийн далан, БЗД, 11 дүгээр хороо”-ны ажлыг Эвт уул ХХК нь гүйцэтгэхдээ Эвт уул ХХК нь гүйцэтгэхдээ чулуун шүдтэй далангийн зарим хэсгийн цементэн зуурмагийн бетоны бат бэхийг үл эвдэх аргаар “Шмитын алх”-аар шалгахад төслийн бат бэхийн шаардлага хангаагүй, сүвгийн хана, ёроолыг зурагт зааснаар хийгээгүй;
- “Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал, УБ, БЗД, 97 сургуулийн өргөтгөл”-ийн ажлыг Молор констракшн ХХК гүйцэтгэжээ. Гадна хаалганд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу зам хийгээгүй, зарим өрөөний шалны хулдаас хуурсан, хаалганы бариул эвдэрсэн, хана цөмөрсөн, аврах гарцын чиглэл заасан гэрлэн тэмдэглэгээг зурагт зааснаар ажиллуулдаг болгох;

ЗТХС-ын багцад:

- 1,061.8 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 3 ажилд давхардсан тоогоор “Хөгжлийн бэрхшээлтэй хүний анхааруулах хавтан”-г хийгээгүй, дутуу хийсэн, явган хүний замын налуу гаргаагүй нь Барилгын тухай хуулийн 11.1.6¹³, 12.1.6¹⁴, 15.1¹⁵ дэх заалтуудыг мөрдөөгүйгээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг зөрчжээ. Тухайлбал:
 - “Хороолол доторх авто замын засварын ажил, багц 3”, гүйцэтгэгч Грэйт роуд ХХК;
 - “Бага тойруугийн байрнуудын дундах авто зам болон явган хүний зам засварын ажил” гүйцэтгэгч Цэлмэг зам ХХК,
- “Хороолол доторх авто замын засвар, 3 км, УБ, БЗД, 19 дүгээр хороо” гүйцэтгэгч Экспресс зам ХХК нь ажлын зурагт заасан газар замын тоноглол болох нэг бүр нь 120,500.0 мянган төгрөгийн үнэ бүхий нийт 1,807,500.0 төгрөгийн 15 ширхэг замын тэмдэг хийгээгүй байсан. Үүнийг аудитын явцад 15 ширхэг замын тэмдгийг гүйцээж тавиулсан болно.

2.2.6 Аудитын шалгалтаар БСШУСС-ын багцын 1 607.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5, ЗТХС-ын 1 456.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 буюу нийт 3 063.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 ТАХ-д зөрчил, дутагдал илэрлээ. Үүний БСШУСС-ын багцын 250 сая төгрөгийн 2 ТАХ-ний зөрчлийг арилгуулахаар 2 албан шаардлагыг хүргүүллээ. Харин БСШУСС-ын 1 381.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ-нд, мөн

¹³ 11.1.6.хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах: барилга байгууламж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг зорчих, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан байхаар төлөвлөгдөн баригдсан байх;

¹⁴ 12.1.6.хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, техникийн шаардлагыг хангасан байх;

¹⁵ 15.1.Барилга байгууламжийн зураг төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан шаардлагыг тусгана.

ЗТХС-ын 1 456.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ-нд, нийт 2 837.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ТАХ-д илэрсэн зөрчлийг аудитын явцад арилгууллаа

2.2.7 Цаашид гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийн ажлын хариуцлагыг сайжруулах, ТАХ-г гүйцэтгэх ажлын явцад барилгын норм, дүрэм, стандартыг мөрдүүлэх, хяналтын зураг, төсвийн үзүүлэлт, тоо хэмжээнд ажлыг гүйцэтгүүлэх шаардлагатай байна.

Захиалагч гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

2.3.1 Захиалагч байгууллага гэрээний хэрэгжилтэд тавих хяналт сул байгаагаас УТХО-аар хэрэгжүүлж байгаа ТАХ-ний ажлын гүйцэтгэл чанаргүй, ажил дутуу, гүйцэтгээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгож байнгын ашиглалтад хүлээн авч байгаа нь нэмэгдэл зардал гарах эрсдэлийг дагуулж байна. Тухайлбал:

- “Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, УБ, СБД, 12, 13, 14 дүгээр хороо”-ны ажлын тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 2018 онд ашиглалтад орох боломжгүй болсон;
- “Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, УБ, СХД, Жаргалант тосгон 116 дугаар цэцэрлэг”-ийн гадна дулаалгын ажлыг зургийн дагуу хийгээгүйг буулгаж дахин хийлгүүлсэн, гэрээнд өөрчлөлт хийгээгүй;
- “Нийт эзэмшлийн орон сууны байрнуудын дээврийн засвар, УБ, БГД, 15, 17 дугаар” зураг төсөв баталгаажигдаагүй, гэрээнд өөрчлөлт хийгээгүй.

Ажлын гүйцэтгэлийг бодитой хянаагүйгээс хийгээгүй ажлын гүйцэтгэлд санхүүжилт олгосон байна.

2.3.2 Захиалагч, зураг төсвийн зохиогч байгууллага ТАХ-г гүйцэтгэх ажлын явцад тогтмол, үр дүнтэй хяналт хийдэггүй, хяналтаар өгсөн үүрэг, даалгаврын биелэлтээ эргэж шалгадаггүй, гэрээг дүгнэж, үүргээ хугацаанд нь биелүүлээгүй гүйцэтгэгчтэй хариуцлага тооцдоггүй, ТАХ-ний ажлын гүйцэтгэлийг газар дээр нь хэмжилт хийж баталгаажуулалгүйгээр санхүүжилт олгож байгаа нь ТАХ ашиглалтад орох хугацааг удаашруулж, ХО-ын үр ашиг буурах, өртөг нэмэгдэх нэг шалтгаан болж байна.

2.3.3 Гүйцэтгэгч ажлаа хугацаанд нь гүйцэтгээгүйгээс батлагдсан санхүүжилтийг бүрэн ашиглахын тулд тухайн жилийн санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулжээ. Тухайлбал:

- “Сургуулийн барилгын өргөтгөл, 450 суудал, УБ, ЧД, 50 дугаар сургууль”, 1 000.0 сая төгрөг;
- “Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал, УБ, ХУД, 114 дүгээр сургууль”, 800.0 сая төгрөг;
- “Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудал, УБ, БГД, Эрдмийн өргөө цогцолбор сургууль”, 800.0 сая төгрөг;
- “Цэцэрлэгийн барилга, 200 ор, УБ, СХД, 16 дугаар хороо”, 750.0 сая төгрөг;

Хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байна.

2.4.1 НЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс, Нийслэлийн дотоод аудитын алба, НАЗХГ, НХОГ-уудаас ирүүлсэн албан тоот, 2018 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлангаас үзэхэд уг байгууллагуудын дотоод аудит, хяналтын албад, нэгжүүд нь Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1¹⁶ дэх хэсэгт, мөн СС-ын 2016 оны 415 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 5 дахь зүйлийн 5.4¹⁷ дэх хэсэгт зааснаар нийслэлд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй ХО-ын ТАХ-ний төсвийн зарцуулалт, барилгын чанарт тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж чадаагүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг, үр нөлөөг төлөвлөх, тооцох эрх зүйн орчин хараахан бүрдээгүй байна.

3.1 Олон Улсын Валютын сангаас хийсэн судалгаагаар УТХО-ын удирдлагыг чадавхжуулах нь ХО-ын үр өгөөж, гарцыг нэмэгдүүлдэг төдийгүй төсвийн ХО-ын удирдлага сайтай улс орнуудын ХО-ын үр дүн тодорхой, үр нөлөөтэй, бүтээмжтэй байдаг бөгөөд бага орлоготой хөгжиж буй орнууд нь УТХО-ын харилцаанд оролцож буй субъектуудыг чадавхжуулах замаар төсвийн ХО-ын үр нөлөөг дээшлүүлэх боломжтой гэсэн зөвлөмжийг өгсөн байна.

3.2 Улсын төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.11¹⁸-д зааснаар “УТХО-ын нийгэм, эдийн засагт үзүүлэх үр ашиг, үр дүнг тооцох аргачлал”-ыг Сангийн сайд 2018 оны 12 дугаар сард 295 дугаар тогтоолоор баталжээ. Энэ аргачлалыг мөрдөгдөж эхэлтэл УТХО-ын үр ашиг, үр нөлөөг төлөвлөх, тооцох эрх зүйн орчин байхгүй байна.

¹⁶ 35.1-д “Аймаг, нийслэлийн Засаг дарга барилгын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ; 35.1.1-д “нутаг дэвсгэртээ барилгын салбарт баримтлах төрийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих”.

¹⁷ Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг үнэн зөв гаргах, төсвийн зарцуулалт, барилгын чанарт тавих хяналтыг Төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна

¹⁸ Хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг харгалзан үр дүнг тооцох аргачлалыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүнд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид:

- Эрх шилжин ирж байгаа УТХО-ын ТАХ-ний сонгон шалгаруулалт, хэрэгжилтийг бүрэн хариуцаж, түүнд тавих хяналтыг сайжруулж, ХО-ын үр нөлөөг тооцож байх.

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, дүүргүүдийн худалдан авах ажиллагааны албадын дарга нарт:

- Үнэлгээний хороог хуулийн дагуу байгуулах талаар гаргаж байгаа алдааг таслан зогсоох замаар ХО-ын үр нөлөөг нэмэгдүүлэх ажлыг эхлүүлэх;
- ХО-ын гэрээт ажлаа чанартай гүйцэтгээгүй гүйцэтгэгчийг цаашид сонгон шалгаруулалтад оруулахгүй байх арга хэмжээг хэрэгжүүлэх;

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, Нийслэлийн Авто замын хөгжлийн газарт:

- Нийслэлд УТХО-ын ТАХ-ний хэрэгжилтийн үе шатны ажилд гүйцэтгэлийн хяналтыг бүрэн хийх,
- Ажлын гүйцэтгэлийг зурагт үзүүлснээр болон ажлын тоо хэмжээ бүрээр газар дээр нь хэмжилт хийж баталгаажуулж байх.
Эдгээрийг үндэслэн санхүүжилтийг олгодог байх, үүнд НЗДТГ-ын СТСХ хяналтаа тавих.

Холбогдох байгууллагуудын санал



Согнохайран дүүргийн Худалдан авах ажиллагааны албанаас 2018 оны улсын төсвийн хөрөнгөөр зохион байгуулсан худалдан авах ажиллагаанд хийгдсэн "Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө" аудитын дүнгалтыг үзсэн зөвшөөрч байна.

ДАРГА  Х.БАТХҮҮ

D:\Admin\Buar 201904\18.01.docx



Тус газраас улсын төсвийн хөрөнгөөр хийж хэрэгжүүлсэн 2018 оны төсөл хөтөлбөрт хийгдсэн аудитын дүнгалтад саналгүй болно.

ДАРГА  Ж.ТОГТОХБАЯР

D:\Admin\2019\Doc\AB
115C500862



Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө, гүйцэтгэлийн аудитын тайланттай санал нэг байна.

ДАРГА  Э.БОЛОРМАА



315067001234

1:405.1605

Тийм бол 1	43		19	19	1	1	26	26	30,361.2
		39,6			19		1,50		
		63.3			,1		5.4		
					87				
					.1				
Үгүй бол 2	19				63	63			

Хүснэгт №2

Тендерт зарцуулсан хоног болон тендерийн хэмнэлт

№	Төсвийн Ерөнхийлөн захирагчийн нэр	Тендерт зарцуулсан хоног		Тендерийн хэмнэлт	
		Нэг бүрээр	Дунджаар		
1	1	ЗГХЭГ	193.0	193.0	151.1
2	2	БОАЖЯ	71	71.0	83.6
3	1	ХЗДХЯ	129	129.0	12.7
5	1	ХНХЯ	149.0	79.8	50.2
6	2		47.0		0.0
7	3		61		0.1
8	4		123.0		114.5
			319.0		164.8
9	1	БХБЯ	146.0	136.3	14.9
10	2		146.0		52.2
11	3		189.0		
12	4		168.0		0.1
13	5		31.0		
14	6		102.0		5.7
15	7		227.0		28.7
16	8		217.0		104.1
17	9		74.0		40.6
19	10		63.0		1.5
			1,363.0		247.8
20	1	БСШУСЯ	70.0	135.4	161.0
21	2		195.0		31.1
22	3		158.0		
23	4		309.0		167.7
24	5		204.0		167.7
25	6		192.0		150.4
26	7		218.0		9.0
27	8		94.0		149.9
28	9		60.0		69.6
29	10		157.0		241.9
30	11		73.0		81.2
31	12		175.0		144.9
32	13		146.0		812.0
33	14		228.0		457.0
34	15		60.0		35.7

35	16		169.0		52.0
36	17		183.0		38.6
37	18		86.0		265.6
38	19		68.0		55.4
39	20		148.0		175.4
40	21		157.0		38.5
41	22		157.0		218.0
42	23		260.0		411.0
43	24		185.0		356.0
44	25		228.0		259.5
45	26		73.0		112.0
46	27		252.0		182.6
47	28		87.0		1,252.9
48	29		154.0		201.3
49	30		182.0		49.3
50	31		182.0		300.0
51	32		68.0		11.0
52	33		73.0		39.8
53	34		151.0		7.9
54	35		262.0		4.2
55	36		216.0		
56	37		71.0		21.4
57	38		97.0		3.2
58	39		97.0		2.6
59	40		51.0		1.5
60	41		75.0		251.2
61	42		14.0		0.1
62	43		21.0		0.3
63	44		21.0		0.2
64	45		37.0		0.1
65	46		63.0		2.0
			6,227.0		6,992.5
64	1	ЗТХЯ	75.0	81.2	11.3
65	2		75.0		12.4
66	3		75.0		22.3
67	4		75.0		40.4
68	5		75.0		10.8
69	6		61.0		7.8
70	7		75.0		205.0
71	8		131.0		404.9
72	9		131.0		86.7
73	10		56.0		132.6
74	11		73.0		100.4
75	12		72.0		14.0
			974.0		1,048.5
76	1	ХХААХҮЯ	76.0	143.2	
77	2		59.0		3.0
78	3		168.0		1.1
79	4		190.0		10.8
80	5		242.0		132.5

81	6		124.0		80.5
			859.0		228.0
					8,929.0

Хавсралт №3

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилт, санхүүжилтийн судалгаа
Тоо, сая төгрөг

№	ТАХ хэрэгжээгүй шалтгаан, тоо, төсөвт өртөг	Төсвийн ерөнхийлөн захирагч			Дүн	
		БСШУСС	БХБС	ХХААХҮС		
1	Тендер оройтсон	Тоо	3	1	1	5
		Төсөвт өртөг	882.0	300.0	90.0	1,272.0
		Санхүүжих дүн	882.0	300.0	90.0	1,272.0
2	Гэрээ хийх зөвлөмж хүргүүлсэн	Тоо	1	0	1	2
		Төсөвт өртөг	1,800.0	-	1,000.0	2,800.0
		Санхүүжих дүн	900.0	-	600.0	1,500.0
3	Гэрээ сунгасан	Тоо	1	3	0	4
		Төсөвт өртөг	500.0	32,566.0	-	33,066.0
		Санхүүжих дүн	500.0	2,559.5	-	3,059.5
4	Гэрээ хүчингүй болгосон	Тоо	0	1	1	2
		Төсөвт өртөг	-	70.0	50.0	120.0
		Санхүүжих дүн	-	70.0	50.0	120.0
5	Гомдол гарсан	Тоо	2	0	0	2
		Төсөвт өртөг	2,780.0	-	-	2,780.0
		Санхүүжих дүн	1,080.0	-	-	1,080.0
6		Тоо	6	2	0	8

	Газрын асуудал шийдэгдээгүй	Төсөвт өртөг	15,840.0	1,876.1	-	17,716.1
		Санхүүжих дүн	7,536.0	430.1	-	7,966.1
7	Тендерийн үнэлгээ хийгдэж байгаа	Тоо	4	1	2	7
		Төсөвт өртөг	5,785.0	20.0	390.0	6,195.0
		Санхүүжих дүн	3,435.0	20.0	390.0	3,845.0
	Дүн	Тоо	17	8	5	30
		Төсөвт өртөг	27,587.0	34,832.1	1,530.0	63,949.1
		Санхүүжих дүн	14,333.0	3,379.6	1,130.0	18,842.6